



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 389

Улаанбаатар хот

**Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалт, Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 81 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн өмчөөс шилжүүлсэн нийт 15,091,836.84 (арван таван сая ерэн нэгэн мянга найман зуун гучин зургаа төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 2,632,235.70 (хоёр сая зургаан зуун гучин хоёр мянга хоёр зуун гучин таван төгрөг далан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Хан Хэнтийн Улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаанд эзэмшүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Октябр, Хан Хэнтийн Улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны дарга Б.Хашмаргад нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Газар эзэмших эрхийг нэр шилжүүлэн баталгаажуулах, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005826
21-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 08 дугаар сарын 28 өдрийн
 389 дугаар тогтоолын хавсралт

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ МАНДАЛ СУМЫН ТҮНХЭЛ ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ТӨРИЙН ӨМЧИД
 ХҮЛЭЭН АВЧ, ХАН ХЭНТИЙН УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНД
 ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон он | Байршил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нийт балансын үнэ (төгрөг) | Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэх өртөг (төгрөг) |
|----------|---------------------------|---------------------|---------------------------|-------------|------------|---|---|---|
| 1 | Цагдаагийн кубоны газар | 2018 | Мандал сум, Түнхэл тосгон | м.кв | 702 | 3,510,000.00 | - | 3,510,000.00 |
| 2 | Цагдаагийн кубоны барилга | 1988 | Мандал сум, Түнхэл тосгон | ш | 1 | 11,581,836.84 | 2,632,235.70 | 8,949,601.14 |
| Нийт дүн | | | | | | 15,091,836.84 (арван таван сая ерэн нэгэн мянга найман зуун гучин зургаа төгрөг наян дөрвөн мөнгө) | 2,632,235.70 (хоёр сая зургаан зуун гучин хоёр мянга хоёр зуун гучин таван төгрөг далан мөнгө) | 12,459,601.14 (арван хоёр сая дөрвөн зуун тавин есөн мянга зургаан зуун нэгэн төгрөг арван дөрвөн мөнгө) |